



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 19 өдөр

Дугаар А/141

Хэрлэн сум

Мал, амьтны сэг зэм устгал, орчны
халдваргүйтгэлийн арга хэмжээг зохион байгуулж,
хяналт тавих ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.13, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.8, 32.1.12 дах заалт, Засгийн газрын 2024 оны 62 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд зудын гамшгийн улмаас хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, орчны халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	Ж.Эрдэнэбат	Онцгой байдлын газрын дарга, хурандаа
Нарийн бичгийн дарга:	Н.Анхбаяр	Мал эмнэлгийн газрын дарга
Гишүүд:	Э.Мөнх-Эрдэнэ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
	Э.Жавхлантөгс	Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн дэд хурандаа
	Ж.Энх-Амгалан	Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
	Э.Хонгорзул	Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга
	Г.Мөнх-Эрдэнэ	Байгаль орчин аялал жуулчлалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Л.Бат-Октябрь	Харгуй ТӨХК-ийн захирал
	Г.Батгэрэл	Хэнтий ус ХХК-ийн захирал

2. Мал, амьтны сэг, зэм устгал орчны халдваргүйтгэлийн ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн дарга (хурандаа Ж.Эрдэнэбат)-д, холбогдох журмын дагуу сэг, зэм устгалын ажлыг зохион

2.

байгуулж, үр дүнг танилцуулж ажиллахыг нарийн бичгийн дарга (Н.Анхбаяр) нарт даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч дарга (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ